- D. Хажуугийн цулцан
- E. Өмнөд цулцан

/107./ Улаанбурханы вакцины 1-2-р тунг хэдэн сарын зайтай хийх ёстой вэ?

- A. 1 сарын зайтай
- B. 3 сарын зайтай
- C. 6 сарын зайтай
- D. Жилийн зайтай
- E. 8 жилийн зайтай

/108./ Фаллогийн дөрвөлд орохгүй гажгийг нэрлэнэ үү

- A. Уушгины артерийн эхлэх амсрын нарийсал
- B. Ховдол хоорондын таславчийн цоорхой
- C. Гол судасны амсар баруун тийш хэлбийх
- D. Тосгуур хоорондын таславчийн цоорхой
- E. Баруун ховдлын ханын зузаарал

/109./ Пиелонефриттэй хүүхдэд цефатаксимыг дараах байдлаар хэрэглэнэ

- A. 6мг/кг –аар тооцож, хоногийн тунг 2 хувааж 10-14 хоног булчинд эсвэл судсанд тарих
- B. 50-100мг/кг –аар тооцож, хоногийн тунг 2-6 хувааж 10-14 хоног булчинд эсвэл судсанд тарих
- C. 2-5 мг/кг –аар тооцож, хоногийн тунг 2 хувааж 10-14 хоног булчинд тарих
- D. 40 мг/кг –аар тооцож, хоногийн тунг 3 хувааж 10-14 хоног уулгах
- E. 10 мг/кг –аар тооцож, хоногийн тунг 1удаа өгч 10-14 хоног булчинд эсвэл судсанд тарих

/110./ Хүүхдийг гэдрэг харуулан хэвтүүлэн нэг хөлийг нь түнхээр нугалан өвдөгний үеэр тэнийлгэхэд бүрэн тэнийхгүй байв. Ямар рефлекс вэ?

- A. Бабинскийн рефлекс
- B. Кернигийн рефлекс
- C. Автомат алхах рефлекс
- D. Бауэрийн рефлекс
- E. Галантын рефлекс

/111./ Хүйнээс нь идээ гарч байгаа, 1 өдөр халуурсан нярайд ямар ангиллаар, ямар тусламж үзүүлэх вэ?

A. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ.



В. Нянгийн хүнд халдвар байж болзошгүй гэж ангилаад, антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

С. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм уулгаад гэртээ хэрхэн асрах талаар эхэд зааж өгнө.

Д. Яаралтай эмнэлэгт хэвтүүлнэ.

Е. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын халдварыг генцианвиолетээр гэрт нь эмчлэнэ.

/112./ Цочмог лейкозыг дараах өвчнөөс ялган оношлоно уу:

А. Цочмог лейкоз

В. Верльгофын өвчин

С. Төлжилт багаслын цус багадалт

1. гемоглобин, улаан эс, ялтсан эс багасах, мөхлөгт эс байхгүй болтол цөөрөх, цагаан эсийн зураглалд завсар гарах

2. ясны чөмгөнд улаан эс, ялтсан эсийн төлжилт эрс дарангуйлагдах

3. ялтсан эсийн эсрэг эсрэгбие илрэх, мегакариоцит, ялтсан эсийн тоо эрс багасах

А. А1, В3, С2

В. А1, В2, С3

С. С1, В2, А3

Д. А2, В3, С1

Е. А3, В1, С2

/113./ 3 настай шингэн алдалтгүй суулгалттай хүүхдэд суулгалт бүрийн дараа ямар хэмжээний шингэн уулгах вэ?

А. 50-100 мл

В. 100-200 мл

С. 500-600 мл

Д. 300-400 мл

Е. 700-800 мл

/114./ 12-оос дээш насанд Курловын аргаар элэгний хилийг олоход хэвийн хэмжээ нь хэд байдаг вэ?

А. 10x9x7

В. 10x9x8

С. 12x7x9

Д. 11x9x7 11x9x7

Е. 11x10x7

/115./ Хүүхдийн зүрхний булчингийн эмгэгшил буюу кардиомиопатийн ангилал, илрэх эмнэлзүйн шинжүүдийг зөв сонгоно уу.

А. Тогтонгишлын хэлбэр

В. Булчингийн зузаарлын хэлбэр

С. Тэлэгдлийн хэлбэр

1. Зүүн ховдол, ховдол хоорондын таславчийн булчин зузаарах, зүрх томрох, өвчүүний зүүн талаарагшилтын шуугиан сонсогдох

2. Ховдлын ханын суналт, тэнийлт алдагдах, тэлэлтийн дүүрэлт багасах, их бага эргэлтэнд тогтонгишил үүсэх

3. Зүүн ховдлын хөндий эрс тэлэгдэх, зүрх томрох, хоёр ба гурван хавтаст хавхлагын харьцангуй дутагдлын шинж илрэх

А. А1, В3, С2

В. А1, В2, С3

С. С1, В2, А3

Д. А2, В3, С1

Е. А3, В1, С2

/116./ Улаан бурхны түгээмэл тууралттай хүүхдийн амны шархлааг генцианвиолетээр өдөрт хэдэн удаа эмчлэх ёстой вэ?

А. 1 удаа

В. 2 удаа

С. 3 удаа

Д. 4 удаа

Е. 5 удаа

/117./ 2 -12 сар хүртлэх хүүхдийн амьсгал олшрох босго хэд вэ?

- A. 1 минутанд 50 буюу түүнээс дээш.
- B. 1 минутанд 40 буюу түүнээс дээш.
- C. 1 минутанд 60 буюу түүнээс дээш.
- D. 1 минутанд 30 буюу түүнээс дээш

/118./ Зөвхөн хөхөө хөхдөг , бор хоолонд ороогүй, 6 сар хүрээгүй хүүхдэд ханиалга намдаах хоргүй зөөлөн ямар эмчилгээ хийх вэ?

- A. Шар тостой аарц
- B. Хөхний сүү
- C. Аньсны ханд
- D. Зөгийн балтай сүү
- E. Уротропин

/119./ Гуурсан хоолойн багтрааны багтраат байдлын үе шат, эмнэлзүйн шинжүүдийг уялдуулан сонгоно уу:

- A. Харьцангуй ээнэгшлийн
- B. Багтраат байдлын
- C. Бүтэлтийн

1. Цонхийх, хөхрөх, судасны лугшилт олшрох, элэг томрох, хавагнах, дүлий уушгины шинж  
2. Арьс цонхийх, захын хөхрөлт, амьсгал гаргалт саадтай, уушги тэлсэн, хүчтэй ханиалга, амьсгал сулрах, нойтон хэржигнүүр  
3. Өнгөц амьсгал, ам ангалзаж хүйтэн хөлс гарах, нэлэнхүй хөхрөлт, зүрхний авиа бүдгэрэх, даралт буурах, айсан байдал илрэх

- A. A1, B2, C3
- B. A2, B1, C3
- C. C1, B2, A3
- D. A2, B3, C1
- E. A3, B1, C2

/120./ Чихний цочмог үрэвсэлтэй хүүхдийн чихний өвдөлтийг намдаахаар өрхийн эмч юу зөвлөх вэ?

- A. Чихэнд фурациллинтэй спирт дусаах
- B. Парацетамолыг 6 цагаар өвдөлт намдтал уулгах.
- C. Тарвагны тос халаагаад чихэнд дусаах.
- D. Чихний ард новокаинтэй блокад хийх
- E. Анальгин, димедролтой тарих.

/121./ Уушгины хатгалгаатай 1 настай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд биеийн байдал нь сайжирсан, ханиалга намдсан, амьсгал минутанд 32 байв. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Эмчилгээг зогсооно
- B. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгнө
- C. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- D. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эмийг үргэлжлүүлэн 5 хоног өгнө
- E. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

/122./ Өрхийн эмч нярайн идэвхитэй эргэлтийг хэдэн удаа хийх ёстой вэ?

A. Төрөхөөс гарсны дараа 72 цагийн дотор анхны эргэлт хийнэ, цаашид 1 сар хүртэл 7 хоног тутам идэвхитэй эргэх ёстой.

- B. Сар тутам нэг эргэх ёстой.
- C. Сарл 2 удаа идэвхитэй эргэх ёстой.
- D. Нярайг ээж нь өрхийн эмнэлэг дээр сард 2 удаа авчирч үзүүлэх ёстой.
- E. Нярайг ээж нь өрхийн эмнэлэг дээр сард нэг удаа авчирж үзүүлэх ёстой.

/123./ Верльгофын өвчний үед төрөлхийн ба олдмол ялтсан эсийн цөөрлийг тайлбарласан дараах онол бий:

- A. Ясны чөмөгний буюу Франкийн
- B. Дэлүүний буюу Кацнельсоны
- C. Дархлаа харшлын буюу Шабаловын

1. Гадна дотор хор, физик, хими, биологийн үйлчлэлээр ялтсан эс үүсэлт дарангуйлагдах  
2. Ялтсан эсийн үүсэх үйл хэвийн ч зах хязгаарт илүүтэй задрах  
3. Харшлын гаралтай ялтсан эсийн тоо цөөрөх, ялтсан эсийн эсрэг эсрэгбие тодорхойлогдох

- A. A1, B3, C2
- B. A1, B2, C3
- C. C1, B2, A3
- D. A2, B3, C1
- E. A3, B1, C2

/124./ Уушгины хатгалгаатай хүүхдийг давтан хэзээ үзэх вэ?

- A. 2 хоноод
- B. 5 хоноод
- C. 7 хоноод
- D. 14 хоноод
- E. 30 хоноод

/125./ 3 настай хүүхдийн чихнээс булаг гараад сар болж байна. Чих өвдөж байна гэж хэлдэггүй, зовиур шаналгаа илэрдэггүй боловч ээж нь үзүүлэхээр авчирсан. Үзлэгээр хоёр чихнээс ногоон булаг гарч байв, өвдөлт ба хөхлөг ургацын үрэвслийн шинжгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

- A. Чихний цочмог халдвар
- B. Чихний архаг халдвар
- C. Хөхлөг ургацын үрэвсэл
- D. Шингэн хулхи
- E. Хэсэг газрын халдвар

/126./ Эбштейны өвчний зүрхний цахилгаан бичлэгт илрэхгүй шинжийг зөв сонгоно уу:

- A. Баруун тосгуурын томрол
- B. Цахилгаан тэнхлэг зүүн тийш хазайх
- C. Цахилгаан тэнхлэг баруун тийш хазайх
- D. АВ дамжуулалт уртсах
- E. Гисийн баруун багцын хориг

/127./ Цус багадалттай хүүхдийг өрхийн эмч хэд хоноод давтан үзэх вэ?

- A. 5 хоноод
- B. 14 хоноод
- C. 30 хоноод
- D. 2 хоноод
- E. 7 хоноод

/128./ Бамбай булчирхайг заавал авах шаардлагатай өвчнийг заана уу.

- A. 4-р зэргийн бахлуур, бамбай булчирхай хэт томорсон хэлбэр
- B. 5-р зэргийн бахлуур, эутиреоид хэлбэр
- C. Бамбай булчирхайн хорт хавдар 3-р шатандаа
- D. Бамбай булчирхайн хортхавдар 1-2 -р шатандаа
- E. Урьдчилсан бамбай булчирхайн хорт хавдар гэж оношлосон

/129./ 9 сартай уушгины хатгаатай хүүхдэд амоксициллин 250 мг шахмалыг яаж өгөх вэ?

- A. 1/4 шахмалаар 12 цагаар
- B. 1/2 –талаар 12 цагаар
- C. 2 ширхэгээр 12 цагаар
- D. 1 бүтнээр 12 цагаар
- E. 1,5 шахмалаар

/130./ Ой хүртэлх хүүхдийн хөдөлгөөн-сэтгэцийн хөгжлийг хэдэн шатад хуваадаг вэ?

- A. 2
- B. 3
- C. 4
- D. 5
- E. 7

/131./ 1 сар 10 хоногтой нярай 2 хоног ханиалгаж байгаа, өчигдөр 38 хүртэл халуурсан зовиуртай, амьсгал 1 минутанд 54 байгаа, өөр эмгэг шинж илрээгүй бол юу гэж ангилах вэ?

A. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, цусны сахар багасхаас сэргийлээд, эмнэлэг яаралтай хэвтүүлнэ.

B. Антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

С. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм уулгаад гэртээ хэрхэн асрах талаар эхэд зааж өгнө.

Д. Яаралтай эмнэлэгт хэвтүүлнэ.

Е. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын халдварыг гэрээр эмчлэхийг ба гэртээ хэрхэн асрахыг заах өгөх, 2 хоноод давтан үзлэгт ирэх.

/132./ Чихний архаг үрэвсэл гэж ангилсан хүүхдэд өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?

А. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

В. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.

С. Чихээсээр чихийг хуурайшуулахыг зааж өгөөд 5 хоноод давтан үзүүлэхийг ба хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө.

Д. Өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.

Е. Котримоксазол хоногт 2 удаа 5 хоног уулгана.

/133./ Хүүхэд 5 сартай, хүнд тураалтай гэж ангилагдсан. Өрхийн эмчид улаан, хөх, цагаан А аминдэм байна. Өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?

А. Улаан А аминдэмээс (200000 нэг) нэг капсулыг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

В. Цагаан А аминдэмээс (50000 нэгж) нэг капсулыг өгөөд, цусны сахар багасахаас сэргийлээд, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

С. Хөх А аминдэмээс (100000 нэгж) нэг капсуулыг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

Д. Цагаан А аминдэмээс нэг капсулыг өгөөд, хооллох талаар эхэд зөвлөгөө өгөөд 5 хоноод давтан үзнэ.

Е. Цагаан А аминдэмээс нэг капсулыг өгөөд, хооллох талаар эхэд зөвлөгөө өгөөд 30 хоноод давтан үзнэ.

/134./ 3 настай цусан суулгалттай хүүхдэд цифрофлоксацин 250 мг шахмалаас яаж уулгах вэ?

А. 1 ш-ээр хоногт 2 удаа 3 хоногийн турш уулга

В. Талаар суулгалт намдтал уулга.

С. Дөрөвний нэгээр хоногт 3 удаа 5 хоног уулгана.

Д. 1 ширхэгээр 6 цагаар 2 хоног уулгана.

Е. 2 ширхэгээр 12 цагаар 5 хоног уулгана.

/135./ 10-12 насны хүүхдийн ходоодны физиологийн багтаамж хэд байдаг вэ?

А. 1000-1300мл

В. 1500-1700мл

С. 1300-1500мл

Д. 1700-2000мл

Е. 2000-2300мл

/136./ Зөвхөн хөхөөр хооллож буй хүүхдэд зуны халуунд хөхүүлэхийн зэрэгцээ шингэн нэмж уулгах хэрэгтэй юү?

А. Хэрэгтэй

В. Хэрэггүй

С. Ус халбагдаж өгөх хэрэгтэй

Д. Жимсний шүүсээр угжих хэрэгтэй

Е. Байхуу цайгаар угжих хэрэгтэй

/137./ Суулгалттай А төлөвлөгөөгөөр эмчлэгдэж буй 5 сартай хүүхдэд 20 мг-тай цайрын бэлдмэлээс ямар тунгаар өгөх вэ?

А. ½ шахмалаар өдөрт 1 удаа 14 хоног

В. ¼ шахмалаар өдөрт 1 удаа 14 хоног

С. ½ шахмалаар өдөрт 1 удаа 5 хоног

Д. 1/4 шахмалаар өдөрт 1 удаа 5 хоног

Е. 1 шахмалаар өдөрт 1 удаа 14 хоног

/138./ 2 настай хүүхэд ханиалгасан ба түүний амьсгал 1 минутанд 39 байна. Та яаж ангилах вэ?

А. Уушгины хүнд хатгаа

В. Уушгины хатгалгаа.

С. Ханиад шуухнаа.

Д. Томуу

Е. Маш хүнд өвчин.

/139./ Багтраа өвчний хөдлөл үеийн үе шат, эмгэгжамыг уялдуулан сонгоно уу.

А. Харшил урвалын дархлааны шат

В. Эмгэг хувирлын шат

С. Эмгэг физиологийн шат

1. Хөөнгө эсийн гадаргад JgE-ийн эсрэгбиетэй харшилтөрөгч нэгдэх

2. Хөөнгө эсийн нэвчимхий чанар ихсэх, эсийн мөхлөг гадагшилах

3. Амин идэвхит бодисуудын нөлөөгөөр эд эрхтэний хэвийн ажиллагаа алдагдах

А. А1, В2, С3

В. А2, В1, С3

С. С1, В2, А3

Д. А2, В3, С1

Е. А3, В1, С2

/140./ Нугасны ус, даралтын хэмжээ нас ахих тутам яаж өөрчлөгдөх вэ?

А. Усны хэмжээ ихсэж, Р буурна

В. Усны хэмжээ ихсэж, Р тогтвортой

С. Усны хэмжээ тогтвортой, Р нэмэгдэнэ

Д. Усны хэмжээ ихсэж, Р нэмэгдэнэ

Е. Усны хэмжээ буурна, Р буурна

/141./ Хялгасан хорхойн халдвар тараагч нь:

А. Муур

В. Нохой

С. Хүн

Д. Амьтны гаралтай хүнс

Е. Бохирлогдсон хөрс

/142./ 5 настай хүүхэд суулгасан зовиуртай боловч орчиндоо идэвхитэй, цангаагүй, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хурдан арилж байв. Хүүхдийг үнэлж зохих зөвлөгөөг өг.

А. Хүүхэд шингэн алдаагүй тул урьдчилан сэргийлэх зорилгоор суулгалт бүрийн дараа 100-200 мл шингэн уулга.

В. Хүүхэд шингэн алдаж болзошгүй тул 4 цагт 1200-2200 мл ШСД-ыг аягаар бага багаар өг.

С. Хүүхэд шингэн алдаж байгаа тул 75 мл/кг жинд тооцоолон 4 цагийн турш

Д. Хүүхэд шингэн алдаж байгаа тул 75 мл/кг жинд тооцоолон 4 цагийн турш ШСДУ уулгана.

Е. Хүүхэд шингэн их алдсан тул эмгэлэгт яаралтай хэвтүүлнэ.

/143./ 8 сартай хүүхэд халуурсан, татсан зовиуртай үзүүлэхэд хүүхдийн халуун 39 хэм, таталт намдсан боловч маш их шаналгаатай, чихнээс булаг гойжоод сар болж байгаа зовиуртай, үзлэгээр чихний ард хүндүүр хавагнасан улайлт байв. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

А. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний архаг халдвар

В. Маш хүнд халууралт өвчин. Чихний архаг халдвар

С. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний цочмог халдвар

Д. Маш хүнд халууралт өвчин. Хөхлөг ургацын үрэвсэл

Е. Маш хүнд халууралт өвчин. Чихний цочмог халдвар.

/144./ Уушгины гялтангийн хуурай үрэвсэл нь байрлалаасаа шалтгаалан эмнэлзүйн өөр өөр шинжүүдээр илрэнэ. Үүнд:

А. Өрцний байрлалтай гялтангийн үрэвсэл

В. Дэлбэн завсрын гялтангийн үрэвсэл

С. Уушгины орой гол хэсгийн гялтангийн үрэвсэл

1. Өвчүү хэвлийгээр өвдөх, юм залгих үед өвдөлт ихсэх

2. Хавирганы нумаар өвдөх, өрцний хөдөлгөөн багасах

3. Цээж, хавирга завсраар өвдөх, рентгенд туузан ба зууван сүүдэр үүсэх

А. А1, В3, С2

В. А1, В2, С3

С. С1, В2, А3

Д. А2, В3, С1

Е. А3, В1, С2

/145./ 39 хэм хүртэл халуурсан 4 настай хүүхдэд парацетамолыг яаж өгөх вэ?

А. 500 мг шахмалаас  $\frac{1}{4}$  шахмалаар 6 цагаар

- B. 500 мг шахмалаас ½ шахмалаар 6 цагаар
- C. 100мг шахмалаас 1 шахмалаар 6 цагаар
- D. 100 мг шахмалаас 1 шахмалаар 8 цагаар
- E. 500 мг шахмалаас ½ шахмалаар 8 цагаар

/146./ Цус багадалттай 1,6 настай хүүхдэд 200 мг төмрийн сульфатыг ямар тунгаар , яаж өгөх вэ?

- A. 1\4 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- B. 1\2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- C. 1 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- D. 1 шахмалаар өдөрт нэг удаа нэг сарын турш.
- E. 1 шахмалаар өдөрт нэг удаа хоёр сарын турш.

/147./ Бамбай булчирхайн эрчимжсэн гиперплазийн гол шалтгаан юунд орших вэ?

- A. Бэлгийн боловсролын үе
- B. Төрөлтийн дараах үе
- C. Цусан дахь өнчин тархины тиреотропын дааврын хэмжээ нэмэгдэх

/148./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангиллыг эмч ямар шинжийг үндэслэн тавих вэ?

- A. Амьсгал олшрох, ханиалгах
- B. Цээж хонхолзох, ханиалгах
- C. Хяхтнаа амьгал, ханиалгах
- D. Өндөр халуурах
- E. Шуугиантай амьгал

/149./ Гаждал цохиулалтын үед хэрэглэх даавар эмчилгээний тунг зөв сонгоно уу:

- A. Преднизолон
  - B. Дексаметазон
  - C. Гидрокортизон
1. 1-2 мг/кг
  2. 5-10 мг/кг
  3. 0.2 -0.4 мг/кг
- A. A1, B3, C2
  - B. A2, B1, C3
  - C. C1, B2, A3
  - D. A2, B3, C1
  - E. A3, B1, C2

/150./ Чихний цочмог халдвартай хүүхдийг 5 хоноод давтан үзэхэд өвдөлт нь ихэссэн, хүүхэд өндөр халуурсан байвал ямар арга хэмжээ авах вэ?

- A. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм өгөөд 2 хоноод давтан үзнэ.
- B. Эмнэлэгт яаралтай хэвтүүлж эмчилнэ.
- C. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эм дээр парацетамолыг нэмж өгнө

D. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм, парацетамол өгөөд, чихийг чихээсээр хуурайшуулахыг зааж өгөөд 2 хоноод давтан үзнэ.

/151./ Хөхлөг ургацын үрэвсэлтэй хүүхдэд өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?

A. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эмийн гараа тун өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

B. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.

C. Антибиотик булчинд тариад гэрт нь 5 хоног эмчилнэ.

D. 2 антибиотик булчинд тариад, өвдөлт намдаах эм, тайвшруулах эм хэрэглээд 5 хоног гэрт нь эмчилнэ.

/152./ Цус багадалттай 1,6 настай хүүхдэд 200 мг төмрийн сульфатыг ямар тунгаар, яаж өгөх вэ?

- A. 1\4 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- B. 1\2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- C. 1 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- D. 1 шахмалаар өдөрт нэг удаа нэг сарын турш.
- E. 1 шахмалаар өдөрт нэг удаа хоёр сарын турш.

- /153./ Мейо-Робсоны шинж ямар эрхтний өвдөлтийг илрүүлдэг вэ?
- A. Нойр булчирхайн толгойн өвдөлтийн цэг
  - B. Нойр булчирхайн их бие, сүүлний өвдөлтийн цэг
  - C. Цөсний өвдөлтийн цэг
  - D. Ходоодны өвдөлтийн цэг
  - E. Хүрээ гэдэсний өвдөлтийн цэг
- /154./ Хооллолтын бэрхшээлтэй 4 сартай хүүхдийг өрхийн эмч хэд хоноод үзэх вэ?
- A. 5 хоноод
  - B. 14 хоноод
  - C. 30 хоноод
  - D. 7 хоноод
  - E. 2 хоноод
- /155./ Ханиад шуухинаатай хүүхдэд шингэнийг яаж хэрэглэх вэ?
- A. Эрүүл үеийхтэй ижил хэмжээний шингэн өгнө
  - B. Шингэн уух дуршлаас хамаарна
  - C. Эрүүл үеийхээс илүү шингэн өгнө
  - D. Бөөлжиж байгаа үед шингэн өгөхгүй
  - E. Шингэн өгөх шаардлагагүй
- /156./ Д аминдэмийн урьдчилан сэргийлэлтийг хүүхдэд хэдийнээс хийх вэ?
- A. 14 хоногтойгоос
  - B. 1 сартайгаас
  - C. 2 сартайгаас
  - D. 3 сартайгаас
  - E. 4 сартайгаас
- /157./ Тархины хуурай бодисын хэдэн хувийг липид эзэлдэг вэ?
- A. 30%
  - B. 40%
  - C. 50%
  - D. 60%
  - E. 70%
- /158./ Шингэн алдалтгүй, цусан суулгалттай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд шингэн алдалтгүй цусан суулгалт намдаагүй, хүүхэд янзандаа байвал ямар арга хэмжээ авах вэ?
- A. Котримоксазолыг үргэлжлүүлэн өгөөд 2 хоноод давтан үзнэ.
  - B. Эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ.
  - C. Хоёрдугаар сонголтын үүсгэгчийн эсрэг эм өгөөд 2 хоноод давтан үзнэ.
  - D. Хоёрдугаар сонголтын үүсгэгчийн эсрэг эм өгөөд 5 хоноод давтан үзнэ.
  - E. Шингэн алдалтгүй тул А төлөвлөгөөгөөр суулгалтыг гэрээр эмчилнэ.
- /159./ Нярайн бүтэлтийн үед хүчил шүлтийн тэнцвэр хэд байвал хүндэвтэр гэж үзэх вэ?
- A. pH 7.35-7.45
  - B. pH 7.35-7.30
  - C. pH 7.30-7.25
  - D. pH 7.20-7.10\*
  - E. pH 7.10 аас бага
- /160./ 3 настай, 12 кг жинтэй хүүхэд 2 хоног суулгасан. Үзлэгээр тайван биш, цочромтгой, арьсны хуниас удаан арилна, шингэн ховдоглон ууна. Хүүхдийг үнэлж ямар арга хэмжээ авах вэ?
- A. Хүнд шингэн алдсан гэж үзээд хураагуур судсанд эхний 1 цагт 30 мл\кг, дараагийн 5 цагт 70 мл\кг жинд тооцоолон Рингер лактатын уусмал юүл.
  - B. Шингэн алдсан гэж үнэлээд 400-600 мл ШСД халбагаар уулга.
  - C. Шингэн алдсан гэж үзээд 4 цагийн дотор 960-1600 мл ШСД бага багаар уулга.
  - D. Хүүхэд шингэн их алдсан тул эмгэлэгт яаралтай хэвтүүлнэ
- /161./ Хүүхдийн хоол боловсруулах тогтолцооны эмгэг хэдэн хамшинжээр явагддаг вэ?
- A. 1
  - B. 3
  - C. 6

D. 9

E. 12

/162./ 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна. Түүний чихэнд хүрэхэд маш их эмзэглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна. Өөр шинжүүд илрээгүй. Хэрхэн ангилах вэ?

A. Рахит

B. Хөхлөг ургацын үрэвсэл

C. Чихний архаг халдвар.

D. Чихний цочмог халдвар

E. Менингит

/163./ Уушгины удамшигч өвчнүүдэд тохирох хамгийн зөв шинжүүдийг уялдуулан сонгоно уу.

A. Уушгины гемосидероз

B. Гудпасчерийн хамшинж

C. Муковисцидоз

1. Уушгийг рентгенд харахад дунд доод хэсгээр толборхог эсвэл торлог сүүдэр харагдана. Зарим үед элэг дэлүү томорч, хурууны үзүүр өргөснө.

2. Цустай цэр гарах, цустай ба уурагтай шээх, цусны шинжилгээнд цус багадалт даамжрах ба рентгенд олон толборхог сүүдрүүд ажиглагдана.

3. Хөлсөнд хлорын хэмжээг тодорхойлоход хэвийнхээс 2-8 дахин ихэснэ

A. A1, B3, C2

B. A1, B2, C3

C. C1, B2, A3

D. A2, B3, C1

E. A3, B1, C2

/164./ Шуугиантай амьсгалтай уушгины хатгалгаатай 10 сартай хүүхдэд сальбутамолыг яаж өгөх вэ?

A. 4 мг шахмалаас  $\frac{1}{4}$  шахмалаар өдөрт 3 удаа, 5 хоног

B. 4 мг шахмалаас  $\frac{1}{2}$  шахмалаар өдөрт 3 удаа 5 хоног

C. 2 мг шахмалаас 1 шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног

D. 2 мг шахмалаас  $1+\frac{1}{2}$  шахмалаар өдөрт 2 удаа 5 хоног

E. 2 мг шахмалаас  $\frac{1}{2}$  шахмалаар өдөрт 5 удаа 3 хоног

/165./ АЦХ-ын гэрийн асаргааны дараах зөвлөмжүүдээс зөвхөн нярай хүүхдэд аль нь өвөрмөц асаргаа вэ?

A. Олон удаа хөхүүлэх

B. Хооллоход саадтай байвал хамрыг цэвэрлэх

C. Өвчний шинж тэмдгийг ажиглах

D. Дулаан байлгах

E. Чийрэгжүүлэх

/166./ 42 настай өвчтөнд "тиреотоксикозын хүнд хэлбэр" гэдэг онош тавигджээ. Эмчилгээний оновчтой тактикийг заана уу.

A. Яаралтай мэс засал хийх

B. Эмийн хавсарсан эмчилгээ

C. Эмээр эмчлэх, оршин суугаа газраар нь булчирхайн эмч хяналтандаа авах

D. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг авах

E. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг тайрах

/167./ 2 настай ханиадтай хүүхдэд цээж хонхолзох шинж илэрч байв. Түүнд өөр зовиур, эмгэг шинж илрээгүй. Эмч хэрхэн ангилах вэ?

A. Ханиад шуухнаа

B. Уушгины хүнд хатгалгаа

C. Уушгины хатгалгаа

D. Багтраа

E. Ларингит

/168./ Таталдамхай өвчний үед таталт тавиулах зорилгоор дараах бэлдмэлийг дараах тунгаар сонгоно:

A. Седуксин 0.5% уусмал

B. ГОМК 20% уусмал



С. Магни сульфат 25% уусмал

1. 50-100 мг/кг

2. 0.2 мл/кг

3. 3 сар хүртэлх хүүхдэд 0.3-0.5 мл, 1 хүртэлх насанд 0.5 мл, 5 хүртэлх насанд 1.0-1.5 мл, 10 хүртэлх насанд 1.5-2.0мл-ээр тарьж хэрэглэх

A. A1, B3, C2

B. A2, B1, C3

C. C1, B2, A3

D. A2, B3, C1

E. A3, B1, C2

/169./ 3 настай хүүхдийн чихнээс булаг гойжоод хагас жил болж байгаа гэтэл өчигдөрөөс эхлээд хүүхэд халуурч, чих өвдөж байна гэж уйлагнасан. Үзлэгээр чихнээс булаг гарч байсан ба чих хөндүүрлэж байсан, чихний ард хөндүүр хаван байгаагүй. Бусад шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

A. Чихний цочмог халдвар

B. Чихний архаг халдвар

C. Хөхлөг ургацын үрэвсэл

D. Шингэн хулхи

E. Хэсэг газрын халдвар

/170./ Тураалтай, цус багадалттай, хооллолтын бэрхшээлтэй гэж ангилагдсан 8 сартай хүүхдийг эмч үзэж зөвлөгөө өгөөд, хамгийн ойрын давтан үзлэгийг хэзээ товлох вэ?

A. 2 хоноод

B. 5 хоноод

C. 10 хоноод

D. 14 хоноод

E. 30 хоноод

/171./ 1-ээс дээш насны хүүхдэд нэмэгдэл хоолыг нэг удаа хэдий хэмжээтэй өгөх вэ?

A. 1 1/4 -1 1/2 аяга буюу 250-300 мл

B. 1 аяга буюу 200 мл

C. Хагас аяга буюу 100 мл

D. Хоёр аяга буюу 400 мл

/172./ 3 настай цусан суулгалттай хүүхдэд цифрофлоксацин 250 мг шахмалаас яаж уулгах вэ?

A. 1 ш-ээр хоногт 2 удаа 3 хоногийн турш уулга

B. Тал шахмалаар суулгалт намдтал уулга.

C. Дөрөвний нэгээр хоногт 3 удаа 5 хоног уулгана.

D. 1/2 ширхэгээр өдөрт 2 удаа 3 хоног өгнө.

E. 2 ширхэгээр 12 цагаар 5 хоног уулгана.

/173./ Сульдаатай хүүхдэд Д аминдэмийн 50000 нэгжийн капсулаас ямар тунгаар өгөх вэ?

A. Сард нэг удаа, 2 нас хүртэл.

B. Даваа гариг бүрт 1 удаа 1 сар өгнө.

C. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа, нийт 7 удаа өгнө.

D. Даваа, Пүрэв гариг бүрт нэг удаа, нийт нэг сар өгнө.

E. Сард нэг удаа нэг нас хүртэл өгнө.

/174./ Тархи бусад эрхтнүүдээс дундажаар хэд дахин их хүчилтөрөгч хэрэглэдэг вэ?

A. 10

B. 15

C. 20

D. 25

E. 30

/175./ Халууралттай, өөр өвчний шинжгүй 1 настай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд халуун нь үргэлжилж, ханиалгаж, амьсгал нь минутанд 42 болсон байв. Ямар арга хэмжээ авах вэ?

A. Ханиад шуухнаа гэж ангилаад ханиад намдаах эм бичиж өгнө.

B. Уушгины хатгалгаа гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм өгнө.

C. Уушгины хатгалгаа. Халууралт. -гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм, ханиад зөөлрүүлэх эм, халуун бууруулах эм өгнө.

D. Уушгины хүнд хатгалгаа гэж ангилаад эмнэлэгт хэвтүүлнэ.

E. Маш хүнд халууралт өвчин гэж ангилаад эмнэлэгт хэвтүүлнэ.

/176./ 4 хүртлэх сартай хүүхдийг зөвхөн хөхөөр хооллох ёстой боловч хэрэв сүү, сүү орлуулагч хэрэглэх зайлшгүй шаардлагатай бол 3 хүртлэх сартай хүүхдэд малын сүүг яаж бэлтгэж өгөх нь зөв бэ?

A. үнээний сүүг цагаан будааны шүүсээр шингэлж өгнө (100 мл буцалсан сүүн дээр 50 мл цагаан будааны шүүс хийж, 2 цайны халбага сахар нэмнэ).

B. үнээний сүүг буцалсан усаар шингэлж өгнө (100 мл буцалсан сүүн дээр 50 мл буцалсан ус хийж, 2 цайны халбага сахар нэмнэ).

C. үнээний сүүг шингэлэх шаардлаггүй (120-130 мл өгнө).

D. үнээний сүүг буцалсан усаар шингэлж өгнө (100 мл буцалсан сүүн дээр 100 мл буцалсан ус хийж, 2 цайны халбага сахар нэмнэ).

E. үнээний сүүг буцалсан усаар шингэлж өгнө (100 мл буцалсан сүүн дээр 100 мл буцалсан ус хийнэ).

/177./ Хүүхдийн тархины цусан хангамж муу, бичил судас багатай тул хүүхдийн тархи амархан хүчилтөрөгчийн дутагдалд ордоггүй.

/178./ Бага насны хүүхдэд мухар ба цутгалан гэдэсний зааг дахь хавхлагын хөгжил сулаас бүдүүн гэдэсний доторх зүйл нарийн гэдсэнд орж болно.

/179./ Насанд хүрэгсдийг бодвол сулралын хугацаа их тул ачааллыг даахдаа муу, амархан туйлддаггүй.

/180./ Хүүхдийн бөөрний сувганцарт натрийн эргэн шимэгдэлт их байдгаас эдэд хаван хурдан үүсдэг.

/181./ Хорей өвчний үед албадмал, эмх замбараагүй хөдөлгөөн илэрдэг учраас хүүхэд “сахилгагүй” нэр авдаг.

/182./ Нугасны урт нурууны ясны өсөлтөөс хоцордог учраас нугасны төгсгөл нас ахих тутам дээшилдэг.

/183./ Булчингийн мэдрэл гэмтсэнээс, мөн бага тархи, дотор чихний гэмтэл эмгэгүүдийн үед хөдөлгөөний зохицол алдагдахыг атакси гэнэ.

/184./ Цус тархины хориг нэвчимхий, мэдрэлийн эсийн бүрхүүлийн нэвтрүүлэмж их тул янз бүрийн цочролын үед мэдрэл хордлого үүсэх нь удаан.

/185./ Сургуулийн өмнөх насны хүүхдийн ЗЦБ-т синусын хэм алдалт илэрч болох учраас эмгэг гэж үзэхгүй.

/186./ Ургийн үед бөөрний эргэх үйл хямарснаас бөөрний байршлын гажиг үүснэ.

/187./ Хүүхдийн бөөрний цусан хангамжийн ихэнх хэсэг нь тархилаг давхаргаар өнгөрдөг тул бөөрний тархилаг ба холтослог давхаргын зааг муу ялгардаг.

/188./ Хүүхдийн үйл хөдлөлийг байнга хоригловол хүүхдийн уураг тархины саатлын процесс давамгайлах учраас неврозын анхдагч сэжүүр бий болж, уур уцаартай, адайр зантай болох хандлагатай.

/189./ Папул гэдэг нь арьснаас дээш овойж гарах учраас тэмтрэхэд мэдэгдэнэ.

/190./ Хүүхдийн бөөрний тунгалгийн судас, гэдэсний тунгалгийн судастай нягт холбоотой байдаг тул гэдэсний халдвар бөөрөнд дамжих боломжтой.

/191./ Бөөр нь биологийн идэвхт бодис ялгаруулдаг тул бөөрний эмгэгийн үед даралт ихсэх, цус багадах, цус бүлэгнэлт буурах зэрэг шинж илэрдэг.

/192./ Хүүхэд хайраар дутвал хүүхэд өвчлөх учраас хүүхэд саатуулах газарт 5 сараас өмнө, эсвэл 2 наснаас өгөх нь тохиромжтой.

/193./ Ясжилтын цэг үүстэл хөндийт яс диафизийн төгсгөлийн мөгөөрсөн эдээс урган уртасна.

/194./ Хүүхдийн булчингийн хөгжил дутмаг байдгаас биеийн цулын харьцаа насанд хүрэгсдийнхээс бага байдаг.

/195./ Нярай хөхүүл хүүхдийн хоол боловсруулах эсэгийн идэвх сул, хэмжээ бага учраас хөндийн хоол боловсруулалт давамгайлна.

/196./ Боталловын цорго гол судасны нумын төгсгөлд цутгадаг учир доод мөч нь дээд мөч, толгойноос хүчилтөрөгчөөр баялаг цусаар хангагддаг.

/197./ Хүүхдийн бөөр илүүдэл шингэнийг түргэн ялгаруулдаг тул шээсний хувийн жин бага байдаг.

/198./ Нас ахих тутам тэнэгч мэдрэлийн зохицуулга сайжрах учраас зүрхний цохилт олширно.

/199./ Хөхөх рефлекс ой хүртэл ажиглагдах учраас хөхүүл насны хүүхэд аманд нь хуруу хийхэд хөхнө.

/200./ Зүрх тасалдах мэт болох нь ээлжийн бус агшилттай холбоотой үүсдэг сэрэл учраас зүрхний бүтцийн өөрчлөлтэй холбоотой байх нь ховор.

/201./ Хүүхдийн бөөрний сувганцар, генлийн гогцоо маш богино тул эргэн шимэх үйл дутмаг байдаг.

/202./ Хүүхдийг их юм мэдүүлэх гэж шахах нь хортой яагаад гэвэл тархи туйлдан ядарч хүүхэд нойр, хоолондоо муудаж цаашилбал мэдрэл-сэтгэхүйн эмгэг ч үүсч болно.

/203./ Хөрсөн ба арьсан үеийн зааг барзгар, суурь хальс дутмаг хөгжилтэй тул хөрсөн үе ховхрох нь хялбар.

/204./ Хүүхдийн шээлэй бүтцийн онцлогтой байдаг учраас бөөрөнд шээс хуримтлагдах хандлагатай.

/205./ Хөхүүл хүүхдийн ходоодны шүүсний ялгаралт бага учир ходоодны орчин сул шүлтлэг байна.

/206./ Рахитын гол урьдчилан сэргийлэлт юу вэ?

- A. Д-Аминдэм уулгах
- B. Нар агаарт гаргах
- C. Усанд тогтмол оруулах
- D. Хөхөөр хооллох
- E. Иллэг хийх

/207./ В төлөвлөгөөгөөр хамар ходоодны хаймсуураар шингэн сэлбэхдээ ямар хэмжээгээр хэдэн цагийн турш сэлбэх вэ?

- A. Цагт 50 мл/кг 5 цагийн турш
- B. Цагт 40 мл/кг 4 цагийн турш
- C. Цагт 30 мл/кг 3 цагийн турш
- D. Цагт 20 мл/кг 6 цагийн турш
- E. Цагт 10 мл/кг 6 цагийн турш

/208./ Хүүхдэд амны шархлааг өдөрт хэдэн удаа эмчлэх вэ?

- A. 1 удаа
- B. 2 удаа
- C. 3 удаа
- D. 4 удаа

- Е. 5 удаа
- /209./ 3 сартай хүүхэд 1 хоног толгойгоо шөргөөж уйлна. Түүний чихэнд хүрэхэд маш эмзэг, чанга уйлна. Чихний ард хөндүүр биш, хавдаргүй байв. Хэрхэн ангилах вэ?
- А. Чихний цочмог халдвар
  - В. Хөхлөг ургацгийн үрэвсэл
  - С. Чихний архаг халдвар
  - Д. Аюултай ерөнхий шинжтэй
  - Е. Маш хүнд өвчин
- /210./ Шингэн их алдалттай үед судсаар сэлбэх нэн тохиромжтой уусмал аль нь вэ?
- А. 10%-ийн глюкозын уусмал
  - В. 5% -ийн глюкозын уусмал
  - С. Рингер Лактатын уусмал
  - Д. 10%-ийн NaCl
  - Е. физиологийн уусмал
- /211./ Нярайг нэг удаа хэдэн минут хөхүүлэх вэ?
- А. 5-10 минут
  - В. 10-15 минут
  - С. 15-20 минут
  - Д. 20-25 минут
  - Е. 25-30 минут
- /212./ Уушгины хатгалгаа, чихний халдвар буюу маш хүнд өвчний үед үүсгэгчийн эсрэг 1-р сонголтын эмийг сонгоно уу?
- А. Ампициллин
  - В. Амоксациллин
  - С. Кларитромицин
  - Д. Тетрациклин
  - Е. Пенициллин
- /213./ Дараах шинжүүдээс аль нь илэрвэл эмнэлэгт яаралтай хэвтүүлэх вэ?
- А. 14 хоногоос дээш ханиалгах
  - В. Халуурах
  - С. Амьсгал олшрох
  - Д. Цустай цэр гарах
  - Е. Чээж хонхолзох
- /214./ Шингэн их алдалттай 10 кг жинтэй хүүхдийг ууж чаддаг болмогц нь 1 цагийн дотор хэдий хэмжээний шингэн уулгах вэ?
- А. 50 мл
  - В. 40 мл
  - С. 30 мл
  - Д. 70 мл
  - Е. 75 мл
- /215./ Цочмог суулгалт гэж юу вэ?
- А. Суулгалт цочмог эхэлж 7 хоногийн дотор намдаж байвал
  - В. Суулгалт цочмог эхэлж 10 хоногийн дотор намдаж байвал
  - С. Суулгалт цочмог эхэлж 14 хоногийн дотор намдаж байвал
  - Д. Суулгалт цочмог эхэлж 14 хоногоос дээш хугацаагаар үргэлжилж байвал
  - Е. Суулгалт цочмог эхэлж 21 хоногоос дээш хугацаагаар үргэлжилж байвал
- /216./ Шарлалттай нярайг хэзээ давтан үзэх вэ?
- А. 1 хоноод
  - В. 2 хоноод
  - С. 5 хоноод
  - Д. 14 хоноод
  - Е. 30 хоноод
- /217./ Дараах тохиолдлын алинд нь гэрээр эмчилж болох вэ?
- А. Унтаарсан буюу ухаангүй
  - В. Уух буюу хөхөө хөхөх чадваргүй
  - С. Чээж хонхолзох

- D. Амьсгалын тоо олшрох  
E. Татах
- /218./ Хүүхдэд цус багадалт байгаа эсэхийг үнэлэхдээ  
A. Хэрэв хүүхэд 6 сар хүрсэн бол бугалганы тойргийг хэмжнэ  
B. Алганы цайлтыг ажиглана  
C. Хоёр хөлд хаван шалгана  
D. Насанд тохирох жинг тодорхойлно  
E. Илт хүнд тураалыг ажиглана
- /219./ Бага жинтэй нярайд хамгийн их тохиолддог бэрхшээл аль нь вэ?  
A. Халдвар  
B. Хооллолтын бэрхшээл  
C. Биеийн дулаан алдалт  
D. Шарлалт  
E. Бүтэлт
- /220./ Шингэн их алдалттай 11 сартай хүүхдэд хураагуур судсаар 1 цагийн дотор хэдий хэмжээний шингэн хийх вэ?  
A. 50 мл/кг жинд  
B. 40 мл/кг жинд  
C. 30 мл/кг жинд  
D. 70 мл/кг жинд  
E. 20 мл кг/жинд
- /221./ 6 сартай, 8 кг жинтэй суулгаж буй хүүхдэд Б төлөвлөгөөний дагуу 4 цагийн турш хэдий хэмжээний шингэн өгөх вэ?  
A. 50-100 мл  
B. 100-200 мл  
C. 200-450 мл  
D. 450-800 мл  
E. 800-960 мл
- /222./ Ямар тохиолдолд хөхлөг ургацгийн үрэвсэл гэж ангилах вэ?  
A. Чихний ард хөндүүр, хавдсан  
B. Чих өвдсөн  
C. Аюултай ерөнхий шинж илэрсэн  
D. Чихнээс их хэмжээний булаг гарсан
- /223./ Шуугиантай амьсгалтай 5 сартай хүүхдэд сальбутамолыг ямар тунгаар өгөх вэ?  
A. 0.5 мг  
B. 1 мг  
C. 2 мг  
D. 3 мг  
E. 4 мг
- /224./ Хүүхдийг хэдэн нас хүртэл дан хөхөөр хооллох вэ?  
A. 3 сар  
B. 6 сар  
C. 1 нас  
D. 2 нас  
E. 5 нас
- /225./ Уушгины хатгалгаатай хүүхдэд амоксациллиныг ямар тунгаар өгөх вэ?  
A. 10 мг/кг  
B. 15 мг/кг  
C. 20 мг/кг  
D. 25 мг/кг  
E. 45 мг/кг
- /226./ Шингэн их алдалттай, 15 кг жинтэй, 3 настай хүүхдэд хураагуур судсаар эхний 30 минутанд хэдий хэмжээний шингэн хийх вэ?  
A. 300 мл  
B. 400 мл  
C. 450 мл

- D. 500мл
- E. 550 мл

/227./ ХӨЦМ-ээр ямар насны хүүхдийг нярай хүүхэд гэж тооцдог вэ?

- A. 1 сартай
- B. 21 хоногтой
- C. 28 хоногтой
- D. 2 сар хүртэлх
- E. 3 сар хүртэлх

/228./ 2 настай, 12 кг хүртэлх жинтэй суулгаж буй хүүхдэд Б төлөвлөгөөний дагуу 4 цагийн турш хэдий хэмжээний шингэн өгөх вэ?

- A. 200-450 мл
- B. 450-800 мл
- C. 800-960 мл
- D. 960-1600 мл
- E. 100-200 мл

/229./ 1.5 настай хүү халуурна, ханиалгана, нүд улайна, биеэр тууралт гарна, хоолондоо муу гэсэн зовууртай. Хүүхэд суулгаагүй. Үзэхэд аюултай ерөнхий шинж илрээгүй, түгээмэл тууралтай, амны хөндийд гүнзгий, өргөн шархлаатай байв. ХӨЦМ-и йн дагуу ангилна уу?

- A. Маш хүнд халууралт өвчин
- B. Халууралт өвчин
- C. Нүд, амны хүндрэлтэй улаанбурхан
- D. Хүнд хүндрэл бүхий улаанбурхан
- E. Улаанбурхан

/230./ ШСД-ны уусмал ямар найрлагатай вэ

- A. Ус, натри хлорид, глюкоз, кали хлорид
- B. Ус, натри хлорид, кали хлорид, глюкоз, натри гидрокарбонат
- C. Глюкоз, натри хлорид, кали хлорид, гурвал натрит цитрат
- D. Глюкоз, натри хлорид
- E. Ус, хлор, кали хлорид

/231./ Хүүхэд хоолондоо муу, эрүүн доорх булчирхай томорсон, гүйлсэн булчирхайд жижиг идээт голомтуудтай байна. Хүүхдийн өвчнийг ангил

- A. Залгиурын арын буглаа
- B. Хоолой залгиурын цочмог үрэвсэл
- C. Залгиурын үрэвсэл
- D. Хоолой залгиурын идээт үрэвсэл
- E. Хоолой залгиурын архаг үрэвсэл

/232./ Парацетамолын хүүхдэд зориулсан шахмал хэдэн мг байдаг вэ?

- A. 100 мг
- B. 200 мг
- C. 300 мг
- D. 250 мг
- E. 500 мг

/233./ Цусан суулгалтыг ямар эмээр эмчлэх вэ?

- A. Амоксациллин
- B. Кларитромицин
- C. Ампициллин
- D. Ципрофлосаци
- E. Тетрациклин

/234./ Нүдний халдварыг ямар эмээр эмчлэх вэ?

- A. Ung Albucidi 20%
- B. Sol Penicillini 1-2%
- C. Ung Prednizoloni 5%
- D. Ung Tetracyclini 1%
- E. Ung Tetracyclini 5%

/235./ Нярайг хоногт хэдэн удаа хөхүүлэх вэ?

- A. 8-аас цөөн

- В. 8 ба түүнээс олон
- С. 7 удаа
- Д. 6 удаа
- Е. 5 удаа

/236./ Хоолой залгиурын идээт үрэвслийн үед тохирох антибиотикийг хэд хоног хүүхдэд уулгах вэ?

- А. 3 хоног
- В. 5 хоног
- С. 7 хоног
- Д. 9 хоног
- Е. 10 хоног

/237./ Гүйцэд төрсөн хүүхдэд намар, өвлийн улиралд рахитаас сэргийлэх зорилгоор Д-аминдэмийг хэзээнээс эхлэх вэ?

- А. 14 хоногтойгоос
- В. 21 хоногтойгоос
- С. 1 сартайгаас
- Д. 2 сартайгаас
- Е. 3 сартайгаас

/238./ Сампингийн эрхийн шинжийг хүүхдийн хаана тэмтэрч үзэх вэ?

- А. Өвчүүний ирмэгээр
- В. Хавирганы ясан ба мөгөөрсөн хэсгийн уулзвараар
- С. Суганы дунд шугамаар
- Д. Суганы арын шугамаар
- Е. Өвчүүн дээр

/239./ Цээж хонхолзох шинж гэж юу вэ?

- А. Амьсгал авах үед чээжний доод хэсэг дотогш татагдах
- В. Амьсгал авахад чээж бүхэлдээ тэлэгдэх
- С. Нярай хүүхдийн чээжний доод хэсэг ялимгүй дотогш татагдах
- Д. Хавирга хоорондын завсар татагдах
- Е. Амьсгал авахад чээж нэлэнхүйдээ дотогш татагдах

/240./ Дараах хүнсний бүтээгдэхүүнээс аль нь төмрөөр илүү баялаг вэ?

- А. Хүүхдийн будаа
- В. Өндөгний шар
- С. Үхрийн элэг
- Д. Төмс
- Е. Лууван

/241./ 3 сартай, 5 кг жинтэй шингэн алдалт бүхий суулгалттай хүүхдэд 4 цагийн турш хэдий хэмжээний шингэн өгөх вэ?

- А. 50 мл
- В. 200-250 мл
- С. 100-150 мл
- Д. 200-450 мл
- Е. 400-700 мл

/242./ Дараахаас аль нь хүнд тураалын шинж вэ?

- А. Алга цайсан
- В. Алга хувхай цагаан
- С. 2 хөл хавантай
- Д. Жин бага
- Е. артерийн даралт бага

/243./ Нэг настай 10 кг жинтэй суулгаж буй хүүхдэд Б төлөвлөгөөний дагуу 4 цагийн турш хэдий хэмжээний шингэн өгөх вэ?

- А. 50-100 мл
- В. 100-200 мл
- С. 200-450 мл
- Д. 450-800 мл
- Е. 800-960 мл

/244./ Хяхтнаа амьсгал гэж юуг хэлэх вэ?

- A. Амьсгал авахад исгэрсэн ширүүн чимээ сонсогдох
- B. Тайван үед амьсгал авахад ширүүн чимээ сонсогдох
- C. Хүүхэд тайван бус үед хяхтнасан чимээ сонсогдох
